

ЮАНЬ ГҮРНИЙ УНАЛТЫН ТАЛААРХ ӨРНӨДИЙН ЗАРИМ ТҮҮХЧДИЙН ҮЗЭЛ

Ж.Баттөр

Монгол Улсын Их Сургууль, Олон Улсын Харилцааны Сургууль

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд судлаач Юань гүрний мөхлийн талаархи Өрнөдийн зарим судлаачдын үзлийг задлан авч үзсэн байна. Тэдгээрийн дунд булчирхайн тахал, үерийн гамшиг, Юаний Алтан ургийнхны цус ойртсоноос болсон төр удирдахуйн хямрал, Монголын цэрэг арми Хятадад суурьшсан болон үе залгамжлах ёс зэргээс үүссэн давуу байдлын алдралууд гэхчилэн өвөрмөц хариултуудыг тоочсон байна. Ингэхдээ Монголын түүхийн онцгой чухал сурвалжуудаар зарим санааг нь батжуулсан байна. Өрнөдийн зарим түүхчдийн үзэл тухайлбал, хонины мах идэх юм уу, архи их ууснаас болж монголчуудын хүч доройтсон гэх мэт үзлийг шүүмжлэв. Ерөнхийдөө Өрнөдийн түүхчдийн дэвшүүлсэн, нотолсон олон санаа нь Монголын түүхийн энэ үеийг тайлбарлахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Түлхүүр үг : Юань гүрний уналт доройтол, үер, булчирхайн тахал, цус ойртох, садар самуун, хаан ширээний төлөө тэмцэл

Юань гүрний уналт мөхлийн талаар олон улс орны түүхчид өөр өөрийн үзэл хандлагаар заримдаа өвөрмөц санаа дэвшүүлсээр байна. Юань гүрнийг уналтыг өмнө нь манайд болон хуучин ЗХУ-ын марксист түүхчид голлон ангийн тэмцэл, Хятадын дарлагдсан тариачдын бослого хөдөлгөөн, Монголын эзэнт гүрний задрал хуваагдал зэрэгтэй холбон тайлбарладаг байсан бол Өрнөдийн түүхчид халдварт өвчин, үнийн хөөрөгдөл, эдийн засгийн инфляци, Монголчууд Хятадад очоод суурьшмал амьдралд шилжих болсноор цэргийн давуу шинжээ алдсан, Монголын Алтан ургийн хаадын угсааныхны цусан төрөл ойртсон, хааны ордон дахь хэмжээгүй садар самуун, төрийн удирдах ёс зарчим алдагдсан гэхчилэн өргөн хүрээнд олон талаас нь судласан байх юм. Энэхүү өгүүлэлд Өрнөдийн түүхчид Юань гүрний уналт доройтлын учир шалтгааны талаар дэвшүүлсэн зарим санаа, бодлыг товч атугай танилцуулахыг зорив.

Дэвид Моргань : Английн Монголч эрдэмтэн, Монголын эзэнт гүрний түүх судлаач, Өрнөдийн түүхчдээс сүүлийн үед нилээд үнэлэгдсээр буй Дэвид Моргань /1/ Монголын эзэнт гүрний сэдэвт бүтээл нь хэд хэд хэвлэгдсэн юм. Түүний бүтээлд Юаний талаарх өнөөгийн түүхчдийн үнэлгээг доорхи байдлаар базан дүгнэжээ: Сүүлийн үеийн түүхчид Юаний талаар урьд өмнөх үеэ бодвол илүү зэрэг үнэлэн дүгнэх болсон. Цаашдаа ихээхэн нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй байна. Хятадын бусад төртэй харьцуулахад Юаний үед хятадууд утга зохиолын талаар өөрсдийгөө илэрхийлэх нь илүү эрх чөлөөтэй байв. Монголчууд Хятадын соёл иргэншлийг хавчин бусниулах бодлого явуулаагүй. Мингийн үе болоод манж Чингийн (Чиэнлун хаан) үе шиг бичгийн хүмүүс, утга зохиолчдыг үй олноор нь хядаагүй. Тодорхой хэмжээнд “Монгол либерализм” оршиж байсан. Монголчууд Хятадуудаас тодорхой зай барих бодлоготой байсан. Хятадуудыг өндөр албанд томилохгүй гэсэн Монголчуудын байр суурь нь авъяаслаг, чадварлаг хятад хүмүүсийг утга зохиол зэрэгт тодрон гарч ирэхэд хүргэсэн. Уул усны зураг, жүжиг, дуурь зэрэг урлагийн нарийн салбарууд хөгжсөний учир нь Монголчууд соёл урлаг өөрөө хөгжих орчинг нь бий болгож байсантай холбоотой. 300 гаруй жил хуваагдмал байсан Хятад орныг нэгтгэсэн нь Монголчуудын бий болгосон энх тайван, эдийн засгийн хөгжил цэцэглэлттэй адил ач холбогдолтой үйл явдал агаад түүнээс хойш Хятадын улс төрийн нэгдмэл байдал дахин алдагдаагүй юм. Монголчууд Хятадыг улс төрийн хувьд нэгтгэсэн төдийгүй Ханжоу-гаас Бээжин хүртэл нийт 1100 бээр “Их Суваг” хэмээх нүсэр асар

их зардалтай ч өндөр үр ашигтай том байгууламж барьснаар эдийн засгийн талаар зангидаж өгсөн байна. Монголчууд худалдааны нэн тааламжтай орчинг бүрдүүлснээр тэр үед Юаньд дэлхийн янз бүрийн бүс нутагтай хийх худалдааны холбоо харилцаа цэцэглэв. Монголчууд Хятадын түүхэнд байгаагүй хуулийн бодлого явуулсан юм. Учир нь Монголчууд албан ёсны ялын хууль дүрэм зарлан тунхаглаагүй бөгөөд харин хувь хаадын журам, хууль тогтоомжуудаар засаглахыг чухалчилж байв. Монголчуудын шүүхийн засаглал нь Хятадын Сүн болон Мин улсын үеийн тогтолцоотой харьцуулахад илүү хүнлэг байсан агаад цаазаар авах ялыг ихээхэн цөөн удаа хэрэглэж байв. Дараагийн хэсэгт "The decline of Yuan power" гэсэн гарчгийн дор Юань улс яагаад мөхсөн талаарх хэд хэдэн дүгнэлт гаргажээ. Тэдгээрийг хураангуйлбал, Монголын Юань гүрэн нь дараах үндсэн хэдэн шалтгаанаас болж мөхсөн гэсэн байна /2/. Үүнд :

Монголын язгууртнуудын хаан ширээний төлөөх тэмцэл

Хубилай хааны үе, түүнийг тэнгэрт хальснаас хойшхи 30 жил Юаний улс төр эмх журамтай, цаг төр намжуу төвшин байв. Түүний ач хүү Төмөр Өлзийтийн үед Монголын бусад ханлигуудтай энх тайвнаар зэрэгцэн орших хэмжээнд хүрсэн байдаг. Харин 1323 онд Шидэбала хааны аминд халдан хороосон цагаас хойш улс төрийн хямрал тасарсангүй. Дараах 10 жилд бүлэглэлүүдийн тэмцэл, иргэний дайн, улс төрийн аллагууд дараалан гарч, хааны суудал дөрөв таван хүний мэдэлд шилжиж байв. 1333 онд 13 настай Тогоонтөмөр хаан болов. Монголын язгууртнуудын хаан ширээний төлөөх тэмцэл нь Юаний төрийг ихээхэн сулруулан, эрч хүчийг нь барсан байна.

Үерийн гамшиг

1194 онд урсгалын чиглэлээ өөрчилсөн Шар мөрөн Юаний үед хэд хэдэн удаа томоохон хэмжээгээр үерлсэн нь энэ мөрний ай саваар тариалан эрхлэх шороон түмэн хятад тариачдыг сүйрүүлсэн хөнөөл учруулжээ.

Халдварт өвчин

1330-аад оноос ялангуяа, 1350-иад онд Юаньд халдварт өвчин дэгдэв. 1331 онд дэлгэрсэн өвчинг орон нутгийн хэмжээнд нь дарж чадсан ч 1353-1354 онд дэгдсэн өвчнийг төдийлөн амар дарж чадсангүй, үй олон хүний амийг авч оджээ. Юаний сүүлч үеийн хүн амын бууралтыг судлаач эл халдварт өвчинтэй холбосон. Чухам ямар өвчин дэгдсэн нь одоо болтол яг таг тогтоож чадаагүй ч ерөнхий байдлаас нь ажвал **булчирхайн тахал** (bubonic plague) гэж үздэг байна. Европт олон сая хүний аминд хүрсэн "Хар үхэл" (Black Death) анх Крымд Монголчууд Каффа хэмээх хот руу дайрч байх үеэс дэгдсэн тул Монголчуудтай холбож үздэг юм байна. Гэхдээ булчирхайн тахлыг монголчууд санаатай дэлгэрүүлсэн бус, Монголын эзэнт гүрний цаг үед харилцаа холбоо, худалдаа чөлөөтэй болсноор хүмүүсийн зорчилын явцад зарим төрлийн вирус, ан амьтны шимэгч хорхой зэрэг нь хүн амьтнаар дамжин тархах болсноос үүсэлтэй ажээ.

Үнийн хөөрөгдөл

Энэ бүхэн дээр нэмээд өмнө зүгт гарсан үймээнээр Их сувагаар зөөх тутрага тасалдав. Ингэснээр тутрагын (ө.х цагаан будааны) үнэ тэнгэрт хадаж, цаасан мөнгийг улам ихээр гүйлгээнд гаргахад хүргэн, инфляци буюу үнийн хөөрөгдлийг дэвэргэсэн нь хүнсний хямралыг бий болгож, тэр нь Хятадуудын эсэргүүцлийг өдөөсөн байна.

Монголчуудын идэвхгүй байдал

Юаний хүн амын дийлэнх болсон Хятадууд бослого хөдөлгөөн өрнүүлэх болсон ч үүний хариуд ямар арга хэмжээ авах вэ гэсэн нэгдсэн төлөвлөгөө Монголчуудад байсангүй. Харин ч бүр хоорондоо эрх мэдэл булаалцалдан тэмцэлдэх болсон байна. Ийм тодорхой бус, наазгай байдал нь Өмнөд Хятадын босогчдыг улам

хүчээ нэгтгэн зангирахад хүргэсэн байна. Монголын Юань гүрний сүүлчийн хаан Тогоон Төмөр Хятадуудыг яахаа мэдэхгүй, төлөвлөгөөгүй сууж байсныг түүхч нэгэн жишээгээр өгүүлжээ. Түүний сайд нарын нэг Баян бүх асуудлын учир нь хэт хятаджсанаас болоод байна гээд “Жан, Ван, Лиу, Ли болон Жао нэртэй хятад болгоныг хөнөөе” гэсэн санал дэвшүүлсэн байна /3/. “Хэрвээ энэ саналыг үр дүнтэй хэрэгжүүлсэн бол Юаний хятад хүн амын 10 хүн тутмын 9-ийг нь устгах байсан” гэж энэ түүхч бичжээ.

Дэвид Куртис Райт: Юань гүрэн үүсэн, мөхсөн шалтгааныг Өрнөдийн томоохон түүхч Дэвид Куртис Райт /4/ ингэж үзсэн байна:

Анх Чингис хаан Хятадыг шуудхан байлдан дагуулах санаа бодол байгаагүй, харин Хүннү нарын адил өөрсөдтэйгээ дайсагналцалгүй байлгангаа зайнаас харилцах бодолтой байсан, Өгөөдэй хаан болохоор эхэндээ умард Хятадын бүх хятад хүнийг устгаад газар нутгийг нь малчдад малын бэлчээр болгон өгөхөөр төлөвлөж байсан ч Хятан зөвлөх Елүй Чуцай суурьшмал тариачдаас байнга их хэмжээний татвар гувчуур авахын ашиг тусыг нотлон сэнхрүүлсээр болиулсан гэжээ.

Харин Мөнх хаан, Хубилай нар Хятадад ойрхон өсөнгөө Хятадын соёл түүхтэй зарим нэг хэмжээгээр танилцсан байсан тул Хятадыг байлдан дагуулах бодолтой болж түүнийгээ ч хэрэгжүүлэхээр чармайсан байна. Мөн тэр хоёр Тан улсын их хаан Тан Тайзунгийн адил Хятадын ч Хуандий, нүүдэлчдийн ч Их хаан болох санаа өвөрлөсөн ч байж болох юм гэсэн байна. Тэрбээр Юань гүрний мөхсөний гол учир нь “Монголчуудын засаглалын тууштай бус, зөрчилдөөнтэй байсанд оршино” хэмээсэн байна. Юаний Монгол хаадыг засаглалын арга хэлбэрээр нь “Хятад маягийн” болон “Монголын уламжлалт” гэж хоёр янзад хувааж болох агаад Хубилай гэхэд “Хятад маяг”-ийн хэлбэрийг илүү дагаж баримталж байсан бол хэд хэдэн хаан нь Монголын уламжлалт засаглалын хэлбэрийг дагасан гэжээ. Энэхүү засаглалын хэлбэрийн тогтвортой бус шинж нь Юаний нийгмийг хямруулсан гэж үзсэн байна /5/.

Жон Кинг Фэйрбэнк /6/ : АНУ-ын нэрт хятад судлаач Жон Кинг Фэйрбэнкийн бүтээлд Монголчууд Хятадыг байлдан дагуулсан гол нууц нь цэргийн давуу зохион байгуулалтанд оршиж байсан, “цэрэгжилтийн хувьд Хятадад Монголын нөлөө байсан гэдэгт эргэлзэх зүйл бага юм.” гэжээ /7/. Ингээд Хятадын цэргийн зохион байгуулалтын онцлог ба тэр нь Монголын цэргийн зохион байгуулалтын төвшинд яагаад хүрээгүй учрыг ийнхүү тайлбарласан байна.

“Хятадын сонгодог эрхэм дээд үзлээр бол тариачин бүр бас өөрийгөө хангаж чадах нөөц бололцоо бүхий чадварлаг цэрэг байх ёстой юм. Цингээс Тан улс хүртэл цэрэгт дайчлан татдаг байлаа. Цин, Хан улсад эрүүл чийрэг эрс хоёр жил цэрэгт алба хаах үүрэг хүлээдэг байжээ. Суй болон Тангийн эхэн үед *фубин* хэмээх цэргийн журам байсан агаад энэ журмаар зарим өрхүүд татварын чөлөөлсний оронд цэрэгт үйлчилж, өөрсдийн тоног хэрэгсэл, хувь ноогдолоосоо хангадаг байв. Түрүү Тан улс голлон баруун хойд зүгт болон нийслэлийн ойролцоо байрлах тус бүр нь 1000 хүнтэй цэргийн 633 анги салбартай байлаа. Фубинг 749 онд тараасан агаад сүүл үеийн Тан болон Сун улсууд ерөнхийдөө муу нэр дагуулсан чадавхи бүхий хөлсний армитай байв.

Өвөр Азийн нүүдэлчдийн соёл хүмүүжил нь Хятадынхаас өөр байсан билээ. Өөрөөр хэлбэл, тариачин бүр чадварлаг цэрэг байх нь мөрөөдөл байсан бол анчин, малчин бүр тун амархан чадварлаг цэрэг болдог байсан нь бодит баримт юм. Киданы нийгмийн үндсэн нэгж болох 300 өрх нь 100 цэргийг дэмжин тэтгэдэг байв. Чингис хаан болохоор 1206 оноос 95 мянгатыг буй болгож, мянгат бүрээ өрхүүд (ар тал), бэлчээрээр хангасан.” хэмээн Монголын цэргийн зохион

байгуулалтын давуу тал нь нүүдэлчин, анчин амьдралын хэв маяг нь оршиж байсныг нотлоод энэ давуу байдал нь Юаний үед алдагдсан гэжээ.

Хятад гаралтай ч Юань гүрний цэргийн зохион байгуулалтын тухай англи хэлээр нэлээд алдартай нэг сэдэвт бүтээл туурвисан **Чи Чин Сяо /8/** Юаний уналтыг мөн л цэргийн бодлого, зохион байгуулалтанд гаргасан алдаанаас болсон гэж үзсэн нь сонирхолтой юм. Тэрбээр, Монголын байлдан дагуулагчид гол нь хүчинд илүүтэйгээр анхаардаг хэвээрээ үлдсэн юм. Тэд цэргийн үзэл бодлоор сэтгэдэг хандлагатай байсан агаад Хятадад “дийлэнх хүн хүч нь эрхшээлдээ орсон үндэстний иргэдээс бүрддэг” армийн шинэ зохион байгуулалт оруулж ирсэн гэжээ.

Энэ номд Монголын цэрэг армийн хэд хэдэн онцлогийг өгүүлсэн байдаг. Тухайлбал: Монголын арми мэргэжлийн шинжтэй (professional), ауруг буюу нилээд сүүл үеийн хэллэгээр цэргийн хуаран байгуулдаг (garrison troops), цол, хэргэм нь үе залгамжилдаг ёс (hereditary military household) зэргийг дурьдаж болно.

- Хятадыг нэгэнт эзлэн дагуулсны дараа Монголын хуарангийн цэргүүд өөрсдийн амь амьжиргаагаа Умард Хятадын нутагт тэдэнд олгосон эзгүйрсэн газруудад өөрсдөө болон боол нарынхаа хүчээр газар тариалан эрхлэн залгуулах хэрэгтэй болсон юм. Тэдний үе залгамжлах цэргийн байлдах чадавхи удалгүй доройтон унав. Монгол офицерууд салангид тусдаа, өөрийгөө мөнхөлсөн цалинтай язгууртнууд буюу эзэн хааны засаг захиргааны цэргийн дээд жигүүр болсон ч ерөнхийдөө Хятад дахь Монголын цэргүүд ядуурцгаасан юм. Энхийн цагт үе залгамжлах цэрэг байна гэдэг сүйрэл болдог ажгуу /9/.

Мөн энэ номонд “Юаний үеийн Монголчууд хийгээд хятадуудын хоорондын хамгийн том ялгаа нь соёл байлаа” гэжээ.

Ялангуяа одоогийн Ар Монголоос очсон хүмүүс Хятадтай эртнээсээ төдийлөн харилцаагүй явж ирсэн агаад үг яриа, хувцас, зан заншил, нийгмийн суурь нь дэндүү ялгаатай байсан нь Монголчууд болоод Өмнөд Сунгийн Хятадуудын хооронд гүүр болох бус соёлын зайг бий болгов.

Юань гүрнийг судласан Канадын Хятад гаралтай түүхч **Жорж Чинжи Жао /10/** Монголын хаадын үр удмын хүүхэд залуусын дунд нас баралт өндөр, өвчлөл их, хойшлох тусам хаад нь хар залуугаараа нас барж байсны шалтгааныг судлаад тун сонирхолтой дүгнэлт хийсэн байна /11/. Тэрбээр юуны түрүүнд Монгол хаадын хооллолт болон архи сархад зэрэг гашуун нясуун ундаа уух соёл, байдлыг анхааран үзжээ. Түүнээс өмнө Жон Массон Смит гэдэг түүхч мөн л Монголын хаадын дундаж наслалтыг судлаад “Монголын ихэнх хаад богино насалж байжээ. Ойрхи Дорнод дахь хаад нь дунджаар 38 насандаа нас барж байсан бол Хубилай хааны залгамжлагчид дунджаар 33 жил наслаж байсан байх юм” гэжээ /12/.

Их Монгол улсын үеийн их хаадын наслалтыг харвал Чингис хаан 65 наслаж, Өгөдэй хаан 56, Гүюг 43, Мөнх хаан 52 жил насласан юм. Юаний хаадаас хамгийн урт удаан насласан хүн бол Хубилай бөгөөд тэрбээр 80 наслажээ. Хубилай хааныг эс оролцуулбал Чингис хааны хэмжээнд насласан хаан байхгүй. Мөн олон хаан бие муутай, хууч өвчтэй байлаа. Юань гүрний Төмөр хаан гэхэд 42 жил насласан ч хаан ширээнд суусан цөөнгүй жил өвчнөөсөө болоод ажиллах чадваргүй байж, Булугхан хэмээх хатандаа төрийн хамаг ажлаа даалгаж байв /13/. Хайсан, Аюурбада, Тугтөмөр хаад ч бие их муутай хүмүүс байжээ /14/.

Юань гүрний судрын Монгол хаадын ургийн бичээсийг унших юм бол Алтан ургийн үр удам ямар нэгэн үл мэдэгдэх, удамшлын гэмээр хачирхам өвчнөөр байнга өвчилж байсан нь харагддаг. Юань улсын судрын 107-р ботид “Хааны овгийн удмын түүх” бий. Тэндээс дараах мөрүүдийг уншиж болно.

Чэнзун хаан (Төмөр) нэг хүүтэй, хаан угсаа залгамжлагч Дэшоу бөгөөд тэр ханхүү багадаа өөд болсон тул хүүхэдгүй үлдсэн юм. Вүзун хаан (Хайсан) хоёр хүүтэй, ууган хүү нь Минзун хаан (Хошила), отгон нь Вэнзун хаан (Тугтөмөр).

Рэнзун хаан хоёр хүүтэй, ууган хүү нь Инзун хаан (Шидабала), отгон хүү Аньгийн Ван (Ван гэдэг нь энд “ханхүү” гэсэн утгатай. Ж.Б) Вудуси-Буха нь багадаа үр хүүхэдгүй өөд болсон. Инзун хаанд үр хүүхэд заяасангүй. Тайдин хаан дөрвөн хүүтэй байлаа. Ууган хүү нь угсаа залгамжлагч ханхүү Алижиба, удаах Жингийн ван Бадима-иржянпү, гутгаар хөвгүүн нь Сяошүэ, отгон хүү нь Юндэн-замбу. Тэд бүгдээрээ багадаа өнгөрсөн бөгөөд өөр хүүхэдгүй байлаа. Минзун (Хошила) хаан хоёр хүүтэй байв. Ууган хүү нь Шүнь хаан, удаахь хүү нь Нинзун хаан болой. Вэньзун хаан гурван хүүтэй байлаа. Ууган хүү нь угсаа залгамжлагч Алатенада агаад тэр хүүхэдгүй байсаар бага залуудаа нас барсан. Удаах хүү нь ханхүү Яньтиэгуси (Яньтөмөр гүүш), отгон хүү нь ханхүү Тайпинна. Тэд бүгдээрээ үр хүүхэдгүй бага залуудаа нас барцгаасан юм.

Нинзун (Иринчинбала) хүүхэдгүй эрт нас барав.

Шүньди (Тогоонтөмөр) хаан гурван хүүтэй байв. Ууган хүү нь Аюуширидара. Нөгөө хоёр нь эрт нас барсан юм /15/.

Ойрхи Дорнод дахь Хүлэгү-гийн байгуулсан Ил хаадын улсад ийм зүйлс мөн адил оршиж байсныг өмнө дурьдсан түүхч Массон Смит бичсэн бөгөөд харин Энн Лэмбтон гэдэг түүхч “Монголчууд Персэд суурьшсанаасаа хойш үр удмаа сайн үлдээгчид байхаа больсон юм.” гэж бичсэн байна /16/.

Монгол хаадын үр удамшлын талаархи дээрх асуудлыг Массон Смит хоол хүнстэй холбожээ. Түүний өгүүлэлд **хүнс тэжээлийн доройтол** буюу “Dietary Decadence” гэсэн нэр томъёог хэрэглэжээ /17/. Юуны түрүүнд хонины мах, архидалтыг анхаарсан бөгөөд архины хувьд гэхэд монголчуудын архи, айрагны спиртийн хувь зэргийг ч нэлээд нарийвчлан гаргажээ. Гэхдээ түүний судлагаанд үнэний ор бий ч бүрэн дагах аргагүй. Хэрвээ хоол хүнсний асуудлаас болж тухайн үеийн Монголын хаад наслахаа больсон бол одоогийн монголчууд ч бүр байх аргагүй юм.

Харин бидний анхаарлыг татаж буй энэ асултанд Жоорж Чинжи Жао тун сонирхол татахуйц хариулт өгчээ. Түүний батлаж байгаагаар Монгол хаадад тохиолдсон энэхүү наслахаа больсон, үр удмаа үлдээж чадахгүй юм уу, өвчлөмтгий болсны гол шалтгаан нь **төрөл ойртолт** (consanguinity), **цус ойртолт** (inbreeding) байсан аж. Жоорж Чинжи Жао-гийн судлагааг хураангуйлан өгүүлбэл, Монголын Алтан ургийн хаад Өгөдэй хааны үеэс эхлэн гагцхүү Хонгирад овгийн бүсгүйчүүдийг хатнаа болгож авдаг, ургийн холбоотой байсан нь ийм байдалд хүргэсэн гэжээ.

Хонгирад аймаг бол эртний Дарлиган монголчуудын нэгэн аймаг юм. XII зуунд хонгирадчууд Эргүнэ гол, Халх гол хавиар нутагтай байжээ. МНТ-ны мэдээгээр тэд Эмэл, Тэргэн, Алхуй гэсэн гурван Хонгирад Буйр нуурын орчим нутаглаж байв. Тэд мөн зарим үед Алтан улсын харьяанд, заримдаа бие даан оршиж, Алтан улс руу довтолж байсан аж /18/. Англи хэлээр гарсан номуудад Хонгирад аймгийг голдуу “Onggirat” гэж бичсэн байдаг. МНТ-ны 61-66-р зүйлүүдэд Тэмүүжинг Хонгирад аймгийн Дай Сэцэний охин Бөртэтэй сүй тавьж байгаа тухай өгүүлдэг. Ялангуяа 64,65-р зүйлүүдэд өгүүлсэн нь:

“64. Манай Хонгирад хэдийнээс бусдын нутаг ба хүнийг булаан тэмцэлддэггүй.

Харь улсыг үл довтолн

Хацар сайт охидоо

Хасаг тэргэнд суулгаж

Хар буур хөллөж

Хатируулж одож

Хаан болсон та нарын

Хатан сууринд дэвшүүлж

Хамт суулгана...

Манай Хонгирад хэдийнээс хацар гуа хатадтай, өнгө сайн охидтой тул зээгийн зүсээр, охидын өнгөөр явна.

65. Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ. Охин хүүхэд өнгө шилэгдэнэ..." /19/

Хонгирад аймгаас хатан авах ёс Юань гүрнийг мөхтөл уламжлагдан үргэлжилсэн. Гэхдээ сурвалж бичгүүдийг үзвэл хатан, бэр буулгах бүртээ уг аймагт очих бус, харин уг аймгаас гаралтай, заримдаа нэг айлын хүү, охин, ач, зээ нартай л хамаатан садангаасаа ч хатан, гэргий эсвэл хүргэн, зээ хүргэн болгон авдаг байжээ. Нэг жишээг энд дурьдаж болно. Хубилай хаан гэхэд Дай сэцэнгийн өрхөөс гаралтай гурван эмэгтэйг хатнаа болгон авч гэрлэсэн байна. Дай сэцэн Анчин, Хуоху, Цө гэдэг гурван хүүтэй байсан. Анчин гурван хүүтэй байжээ. Ууган хүүгийн нэр Чигу, удаах хүү нь Вочиэнь, отгон хүү нь Начин юм. Эхний эмэгтэй нь Анчингийн охин Чабуй, удаах нь Анчингийн ач Туолянь-ийн охин, гуравдахь эмэгтэй нь Начингийн ач хүү Сяньтунгийн охин юм. Гэтэл Хубилай хааны охин Туманлун Анчингийн хүү Волоучинь (Улаачин)-тай гэрлээд, дараа нь Улаачингийн дүү Төмөр, Улаачингийн өөр нэг дүү Манзи нартай ч тус тус гэрлэсэн байдаг /20/. Хубилай хааны хатан Чабуй дөрвөн хүү төрүүлсэн ч дөрвүүл бие муутай, нас богинотой хүмүүс болцгоосон.

Боилогийн шинжлэх ухаанд цус ойртох, төрөл ойртоход үүсдэг олон шинж тэмдгүүдийн дотор бие султай, ухаан санаа дорой, нас богинотой байх үзэгдэл элбэг байдгийг судлаачид тогтоосон. Юань гүрний хаадын нэг Есөнтөмөр (Хятад нэр нь Тайдин) гэхэд өөрийн төрсөн эгчийн охин Садабала-тай гэрлэж байсан нь яах аргагүй л төрөл ойртсон явдал юм.

Рашид ад-Дин ч гэсэн Юаний хаадын өвчлөлийн талаар зарим нэг далд гэмээр дохио өгсөн мэт харагддаг. Үүнийг илүү нягтлан судлууштай. Тухайлбал тэрбээр, Хубилай хааны хан хөвгүүдийн тухай бичихдээ, ууган хүү Доржийнх нь талаар ингэж өгүүлжээ. "Тэр (ө.х Дорж) гэрлээгүй... Тэр Абаха Ханаас ахмад байлаа. Тэр үргэлж өвдөж зовиурладаг байсан агаад **өнөөх хууч өвчнөөр** таалал төгссөн юм" /21/ Англи орчуулганд **"that chronic illness"** буюу **"өнөөх хууч өвчин"** гэж тойруу замаар хэлсэн үг бол эмч мэргэжилтэй Рашид ад-Дин ямар нэг байдлаар Монголын зарим хаадын дунд оршиж байсан төрөл ойртолтоос болсон удамшлын шинжтэй өвчлөлийг хэлсэн ч байж болох юм.

Хааны ордон дахь ужид самуурал

Хятадад олон жил сууж хэд хэдэн сонирхолтой ном бичсэн Жаспэр Бэкэр /22/ хэмээгч түүхч, зохиолч, сэтгүүлч нэгэн 14-р зууны хятад түүхчдийн бүтээлээс иш татан Тогоонтөмөр хааны этгээд бүжиг, наадааны учрыг ийнхүү тайлбарлажээ:

Монголын Юань династийн уналтанд хоёр зүйл холбоотой.... Нэг нь мистизимд автсан явдал, нөгөө нь Шинэ мянганыхны хөдөлгөөний (хятад дахь тариачдын бослого хөдөлгөөн. Ж.Б) өрнөлт юм. Хубилай хааны үеэс хааны ордон болон Төвдийн ламын шашны хооронд ойр дотно хэлхээ холбоос тогтсон байна. Түүний ач нар засгийн эрхэнд гарсан цаг үед эзэн хааны ордон Тантрийн болон Буддын өвөрмөц шүтлэгт эзэмдүүлсэн аж. Тогоонтөмөр болон түүний шадар бараа бологчид Хориотой хотын (Юаний нийслэл Дайдуу дахь хааны ордны цогцолбор. Ж.Б) "Гүн саруул Ордон" гэдэг хэсэгт Төвд лам нарын заавраар садарлах (sexual orgies)-ыг оролцуулаад хар ид шидийн зан үйл үйлддэг байсныг тухайн цаг үеийн хятадууд бичиж тэмдэглэсэн байдаг.

"Хааны өмнө нүцгэн шалдан эр эм хүмүүс хурьцал үйлдэнэ. Заримдаа ханхөвгүүд болон тэдний харьяатууд нэг хөнжилд орж хэвтэцгээх ба бүр насанд хүрээгүй ханхөвгүүд ч оролцоно... Нийт улс орноос хэдэн зуун охидыг сонгон ордонд авчирна." гэж тэр цаг үеийн нэгэн цочирдсон бичгийн хүн тэмдэглэжээ.

"Хаан болон түүний найзууд Буддын бэлгэ тэмдэг бүхий лам, гэлэнгүүдийн хувцас өмсч, гартаа эрхи барьцаана. Буддын шашны алтан болоод улаан өмсгөл

өмссөн арван зургаан охин зааны ясаар үйлдсэн титэм зүүгээд зэрлэг галууны бүжиг бүжинэ.”

Эдгээр нь Монголчууд бүр тартагтаа хүртэл доройтоод бат чанд засаглаж чадахаа байсныг нь харуулж байна /23/.

Дашрамд дурьдахад XVIII зууны сүүлийн хагаст аж төрж байсан Монголын түүхч Рашпунцаг Юань гүрний мөхлийг Тогоонтөмөр хааны ордоны **ужид самууралтай** /24/ холбосон байдаг нь сонирхолтой. Тэрбээр Тогоонтөмөр хаан бүр яагаад самуурах болсон, яам самуурдаг байсныг нь ч “Болор эрих” зохиолдоо ийнхүү өгүүлжээ: “Хама баруун хойд газрын увдист хүнийг хаанд айлтгаж, ордны дотор оруулав. Тэрбээр хаанд юнь чи-шу (хий бясалгал) хийгээд бай-ми (нууц) хэмээх увдисыг сургав. Хаан өдөр бүр тэр увдисаар явах, олон охидыг хурааж ёсноос этгээдээр элдэв зүйл бузар самуун үйлээр наадмуй. Бас Хама бээр хаанд айлтгаруун: “Эдүгээ эзэнд дөрвөн далайн дотнох баян буй боловч төрсөн бие мөнх бусын тул шамдан хичээж жаргаваас зохистой” хэмээсэнд хаан түүнийг маш зөвшөөв. Хаан ер сууринд сууж, жил удсанаар засгийн хэргийг үл хайхран осолдоод, баясгалан жаргалан ташуурч, үргэлжид ордны дотор арван зургаан охины үсийг нь салгаж, хэд хэдэн хэсэгт шанхлаад, тэргүүнд нь зааны шүд мэт малгай, биед нь их ханцуйт аеу, хатгамал улаан торгоны урт охор хормогч цээживч, цацагт шаахай оймс өмсгөн, гарт нь зя-ба-ла бань нэрт юм барьж, тэдний дотор нэгэн хүн хонх барьж хөгжим үүсгэж, тэдгээр охид бүжиглэмүй. Түүнийг тяньму (тэнгэрийн илбэ) бүжиг хэмээн нэрийдэв. Бас арван нэгэн охины үсийг нь унагаж, тэргүүнийг хивээр боогоод, ердийн дээл, Тан улсын малгай, цухал цамц өмсгөн, гарт нь элдэв зүйлийн хөгжмийн зэвсгийг бариулж хөгжим үүсгэмүй...” гэхчилэн гардаг. Тогоонтөмөр хаан бас луун усан онгоц гэх мэт наадах зүйлс хийлгүүлж байнга зугаацан явдаг байсныг ч Рашпунцаг дурьдан шүүмжилжээ /25/. Рашпунцаг мөн Тогоонтөмөр хаан Хятадын улаан малгайтны бослогыг дарахаар төдийлөн оролдоогүйг, тэрхүү ужид завхайрал самууралд уруу татан оруулсан баруун зүгийн газрын Хама хэмээгчийг албан тушаал хайрлалгүй шагнасаар сүүлдээ төрийн их сайд болгосныг нь ч дурьдсан. Хама гэдэг энэ хүн Монголын маш олон ноёдыг хилсээр хороолгуулж байсныг нь ч Рашпунцаг хурцаар шүүмжлэн өгүүлсэн байдаг. (Үргэлжлэл бий.)

Abstract: In this article, the author analyzed some of the Western historians views on the decline and collapse of the Yuan dynasty. In doing so, the author aimed at avoiding the explanations on the decline of Yuan dynasty through the traditional Marxist approaches, like theory of the class struggle, feudal exploitation or social revolutions etc, but at revealing some hidden internal social factors from the writings of Western historians. They tried to find the main reasons of decline of Yuan dynasty in such original and incredible factors, including bubonic plague, flood disaster, crisis in ruling administration methods, consanguinity and inbreeding in the relatives in the ruling family, hereditary military household system of Mongolian army, ill fated changes in nomadic Mongolians arisen from in Chinese new environment etc,. The author tried to add some proofs to their findings in Mongolian, Chinese and Persian historical sources.

Also he criticized the opinions of the Western historians who argued that Mongolian Empire collapsed because of too much mutton consumption or wide spread alcoholism. In general, many ideas of Western historians are very important to understand many mysterious phenomena of this extraordinary and turbulent period of the Mongolian history.

Эшлэл

1. David Morgan, *The Mongols*. Blackwell. Cambridge, Oxford UK., 1999. pp. 126-135
2. Ibid., pp. 132-135
3. I.de Rachewiltz, *Papal Envoys to the Great Khans*, 1971. p. 190.
4. David Curtis Wright, *The History of China*, Greenwood press, Westport, London. 2001. pp. 85-87
5. Ibid., p. 86.
6. John King Fairbank and Merle Goldman, *China : A New History*. The Belknap Press of Harvard University Press. Cambridge, Massachusetts London, England. Eighth printing 1999.
7. Ibid., p. 121
8. Ch'i-Ch'ing Hsiao, *The Military Establishment of the Yuan Dynasty*. Harvard East Asia Monograph 77. Cambridge 5 Harvard University Press, 1978
9. Ibid., p. 122
10. Ibid.,
11. George Qingzhi Zao., "Population Decadence and Dynastic Decline in the Mongol Empire", *Toronto Studies in Central and Inner Asia No, 5*, ed. Michael Gervers and Wayne Schlepp. 2002, pp. 21-32
12. John Masson Smith Jr. "Dietary Decadence and Dynasty Decline in the Mongol Empire", *Journal of Asian History* 34, no. 1 /2000/
13. Юань Ши, Жүнхуа шужу, 1976. Жуань 114. Тал. 2873, Жорж Чинжи жао-гоос дам авав. Түүний дээр дурьдсан өгүүллийн 22-р талаас тодруулан үзнэ үү.
14. Мөн тэнд.
15. Юань ши, 107:2729.
16. A.K.S. Lambton, *Continuity and Change in Medieval Persia* /Albany : State University of New York Press for Bibliotheca Persica of the Persian Heritage Foundation, 1988/, p. 296
17. pp. 35-52
18. Ишбалдан. *Эрдэнийн эрх*. Төвд хэлээрхи сурвалжуудтай харгуулан, монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хэлхээс хийсэн Д.Бүрнээ. Хянан тохиолдуулсан доктор, проф. Ш.Чоймаа. УБ. 2006. 77-р тал
19. *Монголын нууц товчоо*. Орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлж, удиртгал, үгсийн тайлбар бичсэн Ц.Дамдинсүрэн. Редактор Ш.Гаадамба. УБ. 1976. 31-р тал
20. Энэ тухай ЮУС-ын 109 болон 118-р ботиудаас илүү дэлгэрүүлэн үзэж болно.
21. Rashid Al-din, *Successors of Genghis Khan*, Trans. by John A. Boyle Columbia University Press
22. Jasper Becker, *The Lost Country, Mongolia Revealed*, Sceptre edition 1993. pp. 6-7.
23. Рашпунцаг, *Болор эрх*, тэргүүн, дэд дэвтэр. Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, 24. Д.Бүдсүрэн. Хянан тохиолдуулсан доктор, проф. Ш.Чоймаа. УБ. 2006.
24. Рашпунцаг, *Болор эрх*, 476-478-р талууд.